



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар A/363

Мөрөн сум

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хөвсгөл аймаг дахь төрийн Аудитын байгууллагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийн гүйцэтгэлийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар, “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”, “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Б.Оюунтуяа), Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), Санхүүгийн хяналт аудитын алба (Г.Мөнхтулга), сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлж сум, байгууллагуудын 2022 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд гаргаж хэрэгжүүлэн, заасан хугацаанд тайлагнаж, өөрийн төсөвт хамаарах хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулж ажиллахыг бүх шатны төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6717010731

Аймгийн засаг даргын 2023 оны 6.6.
дугаар сарын 23. нийт өдрийн 4/33 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль жуурманд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, мөрдүүлэх	-НББ-ын бодлогын баримт бичгийг холбогдох хууль жуурманд нийцүүлэн шинэчлэн боловсруулна.	Санхүү төрийн сангийн хэлтэс	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах, Мал хамгаалах сангаас ААН, байгууллагуудад олгосон өвс тэжээлийн тооцоог цэгцэлэх.	-Чанарын шаардлага хангахгүй өвс нийлүүлсэн эсэх	-Мал хамгаалах сан	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	Түрээсийн орон сууцны түрээсийн гэрээ байгуулаагүй айл өрхүүдтэй түрээсийн гэрээг байгуулж хуримтлагдсан авлагыг бууруулах чиглэлээр бодитой арга хэмжээ авах. Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах,	-Төлбөрийн дутуу тооцоотой иргэдтэй тулгalt хийх -Мэдэгдэл хүргүүлэх -Оршин суугчидтай хийх гэрээнд өөрчлөлт оруулах талаар ИТХ-р баталсан ажлын хэсгийнхэн МУХБ-тай биечлэн улзах, хамтран ажиллах -Гэрээнд өөрчлөлт оруулах талаар саналыг МУХБ-нд хүргүүлсэн хариуг эцсийн шатанд шийдвэрлүүлж иргэдтэй гэрээг байгуулж, хуримтлагдсан өр авлагыг төлүүлж цэгцлэх	-Орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн газар
4	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтгаар бий болсон, төсөл хөтөлбөрөөр дамжин ирж байгаа хөрөнгийн бүртгэл хадгалалт хамгаалалтыг сайжруулах, тайланд тусган хууль журамд нийцүүлэн тайлгаха.	-Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлэн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	-Санхүү төрийн сангийн -Орон нутгийн өмчийн газар - Бүх шатны төсөв захирагчид	Орон нутгийн өмчийн газар
5	Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах, дахин гаргахгүй байхад анхаарч төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг Төрийн аудитын газар болон СТСХ-т хуулийн хугацаанд	-Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

6	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах</p>	<p>-Шилэн дансны мэдээллийг цаг хугацаандаа бүрэн оруулах, оруулж буй эсэхийг хянах -оруулсан мэдээлэл үнэн зөв байх, үнэн зөв эсэхийг хянах -Шилэн дансны тайланг илгээх, илгээсэн эсэхийг хянах -хэрэгжилтийг үнэлж зөвлөмж гаргах</p>	<p>- Бүх шатны төсөв захирагчид -санхүү хяналт аудитын газар</p>	
---	---	---	---	--------------

Аймгийн засаг даргын 2023 оны 06.
дугаар сарын 23. нийт өдрийн 1/6 дугаар
захирагчийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсвийг бодит тооцоолол судалгаа, өмнөх оны гүйцэтгэл болон шинээр хэрэгжиж байгаа болон одоо мөрдөгдөж байгаа хууль журмандаа нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөн саналаа ирүүлэх	-Орон нутгийн төсвийн төслийг холбогдох маягт, аргачлалын дагуу бэлтгэх, хянуулах, батлуулах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн үр ашигийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах	-хэмнэж болох зардлын судалгаа гаргаж бодит үр дүнд хүрэх	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	Төсвийн орлогыг бүрдүүлэхдээ орлогын тооцоо, судалгааг нэр тэрлөөр нь үндэслэлтэйгээр тооцоолон боловсруулж биелэлтийг жигд хангаж, төсвийн захирагчдын хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хангуулж ажиллах	-Татвар төлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах -Орлогын сар бүрийн бүрдэлтэд хяналт тавьж удирдлагуудыг мэдээллээр хангах	-Санхүү төрийн сангийн хэлтэс -Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

Аймгийн засаг даргын 2023 оны 06.
дугаар сарын 25.. ний өдрийн/153 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

**“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР
НӨЛӨӨ, ҮР ДҮН” “УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” -Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төлөвлөлтийн шаардлага хангасан магадлалд орсон зураг төсөвтэй, Барилга, байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг хууль, дүрэмд заасны дагуу зохион байгуулах,	- Магадлалд орсон Зураг төсөвтэй хөрөнгө оруулалт батлуулах -Зураг төсөвгүй батлагдсан төсөл арга хэмжээний тоог бууруулах	ОНӨГ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
2	Төлөвлөлтийн шаардлага хангасан магадлалд орсон зураг төсөвтэй, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой, төсөл арга хэмжээг төлөвлөх.	-Зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалт мөн эсэхэд анхаарах. -Нийгэм, эдийн засгийн үр ашиг, хөрөнгийн урсгал зардлыг тооцох.	Сумдын ЗДТГ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
3	Хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэд, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн жагсаалтаар ОНХС-ийн төлөвлөлтийг батлуулах	-Иргэдийн саналыг цахим болон цаасаар авах. -Санал аваагүй төсөл арга хэмжээг батлахгүй байх, Батлуулахгүй байхад ИТХ-ын төлөөлөгчдийг чиглүүлж ажиллах.	Сумдын ЗДТГ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
4	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг гүйцэтгэж буй байгууллагатай байгуулсан гэрээний үр дүнг тооцож, үнэлэх	-Гэрээг байгуулах, гэрээний биелэлтийг ЗДЗ-ийн хуралд тайлагнах	Барилга захиалагчийн хяналтын төв	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
5	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төсөл арга хэмжээний Зорилго зорилт хүрэх үр дүнг тооцоолох, эдийн засаг болон нийгмийн үзүүлэлтүүдэд нөлөөлөхүйц, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч төлөвлөх.	-Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалыг баримталж төлөвлөлт хийх.	Аймаг, сумдын ЗДТГ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
6	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлэх,	-Хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэж, ХШҮ-ээр дүгнүүлэх. -Дүгнэлтийг ил тод олон нийтэд мэдээлэх.	Сумдын Засаг дарга нар	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс
7	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож	-Дүгнэлтийг тооцож ажиллаж хэвших	Сумдын Засаг дарга нар	Хөрөнгө оруулалт,

	буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлт гаргаж байх.			хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
8	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтыг сайжруулах.	-Хөрөнгийг ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах	ОНӨГ, Сумдын ЗДТГ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
9	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтад хяналт тавьж ажиллах	- 3Г-ын 2021 оны 160 дугаар тогтоолын дагуу хяналт тавих -Үе шатны хуваарийн дагуу санхүүжилтийг олгох	Сумдын Засаг дарга нар	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс